



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК

Гүйцэтгэх захирал С.Энхтөр

Утас: 95957791

Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо

Утас: 90098901

Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СҮХБААТАР АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА А.ЧУЛУУНБАТ ТАНАА

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518390  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.08.25 № 108

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан бөгөөд 133,911.0 мянган төгрөгөөр бууруулж 660,752.5 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэл 99.9 хувийн хэрэгжилттэй байна.

### Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтээс 6.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн. Үйл ажиллагаатай холбоотой зардлын зарцуулалтыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл

ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,715,888.00</b>	<b>7,288,500.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8,715,888.00	7,288,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,715,888.00	7,288,500.00
35410	Бичиг хэргийн материал	280,000.00	880,000.00
35420	Аж ахуйн материал	6,890,948.00	5,920,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,544,940.00	488,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>137,844,070.62</b>	<b>128,653,582.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	137,844,070.62	128,653,582.73
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	137,738,515.18	126,791,582.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,207,606.00	15,207,606.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,281,493.74)	(4,428,680.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	207,750,000.00	207,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(117,625,000.12)	(152,250,000.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,513,600.00	43,895,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,393,336.58)	(17,892,481.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,036,290.00	57,419,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,469,150.38)	(22,910,151.23)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	105,555.44	1,862,000.00
39301	Програм хангамж	1,330,000.00	3,325,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,224,444.56)	(1,463,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>146,559,958.62</b>	<b>135,942,082.73</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>146,559,958.62</b>	<b>135,942,082.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	146,559,958.62	135,942,082.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	43,155,439.00	43,155,439.00
51101	Өмч: - төрийн	43,155,439.00	43,155,439.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	96,960,763.11	86,342,886.22
51210	Өмнөх үеийн үр дүн	96,960,763.11	96,960,762.11
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,617,875.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,443,756.51	6,443,757.51
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>146,559,958.62</b>	<b>135,942,082.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>863,232,500.00</b>	<b>1,156,043,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>7,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	7,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>863,232,500.00</b>	<b>1,149,043,900.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	196,480,000.00	186,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,960,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,920,000.00	19,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	167,600,000.00	166,600,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	660,752,500.00	963,043,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	660,752,500.00	963,043,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	6,000,000.00	-
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	6,000,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>882,795,195.38</b>	<b>1,166,661,775.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>882,795,195.38</b>	<b>1,166,661,775.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	700,364,242.80	966,385,688.24
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	271,569,599.65	289,872,582.36
210101	Үндсэн цалин	266,199,199.65	217,206,190.21
210102	Нэмэгдэл	-	39,474,969.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,698,189.27
210104	Урамшуулал	5,370,400.00	11,493,232.89
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,172,300.00	36,393,749.04
210201	Тэтгэврийн даатгал	23,732,204.81	24,983,072.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,995.19	3,127,371.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,813,800.00	2,332,481.82
210204	Ажилгүйдлийн даатгал	562,800.00	536,781.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,627,500.00	5,414,041.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	800,000.00	-
210304	Байрны түрээс	800,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,974,265.77	51,487,580.45
210401	Бичиг хэрэг	5,099,730.30	5,987,982.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	33,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,599,619.47	3,999,598.45
210404	Ном, хэвлэл	1,999,867.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,275,049.00	5,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,000,000.00	5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	5,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,206,770.00	19,066,200.00
210604	Урсгал засвар	25,206,770.00	19,066,200.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	4,697,500.00	10,948,000.00
210702	Дотоод албан томилот	4,697,500.00	10,948,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	152,908,564.00	313,602,864.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	149,686,300.00	311,297,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,264.00	181,764.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>170,035,243.38</b>	<b>240,014,712.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,809,000.00	143,381,538.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,130,605.00	48,447,786.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,095,638.38	48,185,387.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>182,430,952.58</b>	<b>200,276,087.65</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>182,423,885.00</b>	<b>200,271,480.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,205,400.00	30,721,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	172,218,485.00	169,549,980.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,067.58</b>	<b>4,607.65</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,067.58	4,607.65
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(19,562,695.38)</b>	<b>(10,617,875.89)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>510,484.10</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	510,484.10	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(510,484.10)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(20,073,179.48)</b>	<b>(10,617,875.89)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>863,232,500.00</b>	<b>1,149,043,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>863,232,500.00</b>	<b>1,149,043,900.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>196,480,000.00</b>	<b>186,000,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,960,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,920,000.00	19,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	167,600,000.00	166,600,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>666,752,500.00</b>	<b>963,043,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	660,752,500.00	963,043,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	6,000,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>857,032,600.00</b>	<b>1,117,049,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>857,032,600.00</b>	<b>1,117,049,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>674,601,647.42</b>	<b>916,322,912.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>271,289,599.65</b>	<b>289,872,582.36</b>
210101	Үндсэн цалин	265,919,199.65	217,206,190.21
210102	Нэмэгдэл	-	39,474,969.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,698,189.27
210104	Урамшуулал	5,370,400.00	11,493,232.89
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,172,300.00</b>	<b>36,393,749.04</b>

210201	Тэтгэврийн даатгал	23,732,204.81	25,180,857.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,995.19	2,923,371.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,813,800.00	2,338,697.06
210204	Ажилгүйдлийн даатгал	562,800.00	536,781.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,627,500.00	5,414,041.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>800,000.00</b>	<b>-</b>
210304	Байрны түрээс	800,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,099,166.77</b>	<b>51,499,580.45</b>
210401	Бичиг хэрэг	4,999,730.30	5,999,982.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	33,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,599,619.47	3,999,598.45
210404	Ном, хэвлэл	1,999,867.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,499,950.00	5,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	5,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,059,770.00</b>	<b>20,176,200.00</b>
210604	Урсгал засвар	28,059,770.00	20,176,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,697,500.00</b>	<b>10,948,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,697,500.00	10,948,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>169,671,859.00</b>	<b>313,602,864.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,449,595.00	311,297,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,264.00	181,764.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>122,811,452.00</b>	<b>188,829,936.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,327,300.00	140,317,150.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,484,152.00	48,512,786.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>182,430,952.58</b>	<b>200,726,087.65</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>182,423,885.00</b>	<b>200,721,480.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,205,400.00	30,721,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	172,218,485.00	169,999,980.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,067.58</b>	<b>4,607.65</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,067.58	4,607.65
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,199,900.00</b>	<b>31,994,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,199,900.00</b>	<b>31,994,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,199,900.00</b>	<b>31,994,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,199,900.00</b>	<b>31,994,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,199,900.00	31,994,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,199,900.00)</b>	<b>(31,994,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,155,439.00	6,443,756.51	185,662,510.15	235,261,705.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,611,122.00)	(7,611,122.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,155,439.00	6,443,756.51	178,051,388.15	227,650,583.66
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(20,061,691.28)	(20,061,691.28)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,155,439.00	6,443,756.51	96,960,763.11	146,559,958.62
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,155,439.00	6,443,756.51	96,960,763.11	146,559,958.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1.00)	(1.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,155,439.00	6,443,756.51	96,960,762.11	146,559,957.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	1.00	-	1.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,617,875.89)	(10,617,875.89)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,155,439.00	6,443,757.51	86,342,886.22	135,942,082.73

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	963,043,900.00	963,039,571.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	963,043,900.00	963,039,571.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,322,400.00	922,318,091.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,206,700.00	287,203,819.36
210101	Үндсэн цалин	214,506,700.00	217,206,190.21
210102	Нэмэгдэл	43,500,000.00	39,474,969.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,200,000.00	21,698,189.27
210104	Урамшуулал	-	8,824,469.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,080,300.00	36,079,891.04
210201	Тэтгэврийн даатгал	24,456,300.00	24,866,999.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,324,800.00	2,923,371.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,906,000.00	2,338,697.06
210204	Ажилгүйдлийн даатгал	581,200.00	536,781.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,812,000.00	5,414,041.24
2104	Хангамж, бараа материалын зардал	51,500,000.00	51,499,580.45
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	5,999,982.00
210402	Тээвэр, шатахуун	33,500,000.00	33,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	3,999,598.45
210404	Ном, хэвлэл	3,000,000.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,000,000.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5,000,000.00	5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	5,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,176,500.00	25,176,200.00
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	20,176,500.00	20,176,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,948,000.00	10,948,000.00
210702	Дотоод албан томилолт	10,948,000.00	10,948,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	318,098,100.00	318,097,864.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	311,297,100.00	311,297,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,000.00	181,764.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,495,000.00	4,495,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	188,312,800.00	188,312,736.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,800,000.00	139,799,950.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,512,800.00	48,512,786.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	40,721,500.00	40,721,480.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,721,500.00	40,721,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721,500.00	30,721,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	9,999,980.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	963,043,900.00	963,039,571.35
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	963,043,900.00	963,039,571.35
132001	Орон нутгийн төсвөөс	963,043,900.00	963,039,571.35
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>21.00</b>	<b>21.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3.00	3.00

## 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	<b>I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>185,999,721.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>185,999,721.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		25,999,721.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		2,668,763.00
210104	Урамшуулал		2,668,763.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		313,858.00
210201	Тэтгэврийн даатгал		313,858.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	23,017,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		23,017,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	160,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		160,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		160,000,000.00
	<b>II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	186,000,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		186,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		166,600,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй гэж үзэж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,617.9 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	8,715.9	7,288.5	(1,427.39)
Үндсэн хөрөнгө	137,844.1	128,653.6	(9,190.49)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>146,560.0</b>	<b>135,942.1</b>	<b>(10,617.88)</b>
Засгийн газрын хувь оролцоо	146,560.0	135,942.1	(10,617.88)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>146,560.0</b>	<b>135,942.1</b>	<b>(10,617.88)</b>

- *Бараа материал данс 1,427.4 мянган төгрөгөөр буурсан бөгөөд 97,910.1 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 99,337.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан.*
- *Үндсэн хөрөнгө данс 9,190.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд шинээр худалдан авсан 31,994.9 мянган төгрөгийн хөрөнгө, 29 нэр төрлийн анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ нөхсөн 16,234.5 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасан, 7,000.0 төгрөгөөр дахин үнэлж стандартын дагуу бүртгэл хөтлөн бүртгэж, элэгдлийн зардал байгуулсан нөлөөлжээ.*

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын тайлант оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 794,223.9 мянган төгрөг, нийт зарлагыг 794,223.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 168,820.0 мянган төгрөгийн зардлыг нэмж баталсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 44-р зүйлийн 44.2, 48-р зүйлийн 48.1, Монгол улсын Засгийн Газрын 2021 оны 12-р сарын 31-ны 402 тоот тогтоолыг үндэслэн Аймгийн ИТХ-ын 2022 оны 08 тоот тогтоолоор ИТХ-ын төлөөлөгчдийн урамшуулал олгохтой холбоотойгоор зардал нэмж төсөвлөгдсөн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 963,043.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 963,039.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 963,039.6 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төлөвлөгөөний гүйцэтгэл 4.3 мянган төгрөгөөр хэмнэсэн ба цалин хөлс 2.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын зардал 0.4 мянган төгрөг, бусад зардал 1.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагаа	474,325.3	474,321.0	4.3	99.9%
2	80224 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	308,197.1	308,197.1	-	100
3	80802 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тусламж, дэмжлэг	30,721.5	30,721.5	-	100
4	80802 Ахмадуудад олгох дэмжлэг урамшуулал	10,000.0	10,000.00	-	100
5	81102 Бараа үйлчилгээний бусад зардал	68,300.0	68,300.00	-	100
6	81549 Бараа үйлчилгээний бусад зардал	1,500.0	1500.0	-	100
7	82201 Бараа үйлчилгээний бусад зардал	70,000.0	70,000.0	-	100
<b>НИЙТ</b>		963,043.9	963,039.6	4.3	99.9%

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 13 сумын хамтарсан багийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 6,600.0 мянган төгрөг, цагаатгалын ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн зардалд 7,000.0 сая төгрөг, сумдын ИТХ-ын Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд зориулан сургалт зохион байгуулахад 12,400.0 мянган төгрөг, удирдах зөвлөлийн шийдвэрээр хэлмэгдэгсдийн ар гэрт хүндэтгэл үзүүлэх, нөхөн төлбөрийн зардал болгож /3 иргэнд/ 160,000.0 мянган төгрөг нийт 186,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа, гүйцэтгэж, туслах аудитор Т.Цагаанбаяр, чанарын хяналтыг аудитор С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 3,021.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,266.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан зардлыг хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд анхаарал татахуйц өсөлт байхгүй байна. Зардлууд 0.01% хувь буурсан.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 95 мэдээллээс, хугацаандаа оруулсан 86 мэдээлэл хугацаандаа мэдээлэгдсэн байна. Хугацаа хоцорсон 9 мэдээлэл байна. Хугацаа хоцроосон нийт мэдээлэлд 124,350.0 төгрөгийн мэдээлэл багтжээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж 2021 онд хүргүүлсэн боловч дахин давтагдсан тул албан шаардлага хүргүүлэх.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 онд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 .Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	464,710.8	1	464,710.8	100
Албан шаардлага	1	5,581.5	1	5,581.5	100
Нийт дүн	2	470,292.3	1	470,292.3	100

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31,449.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 31,449.6 мянган төгрөгийн цалингийн урамшуулалаас нийгмийн даатгал тооцоогүй, өмнөх онд өгсөн худалдан авалтын гүйлгээ хийхдээ цахим баримтаар баталгаажуулж байх, шилэн дансны тухай хууль мөрдөж ажиллах тухай өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй зөрчлүүдэд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 5.1 Албан шаардлага.

Иргэдийн төлөөлөгчдөд олгосон үр дүнгийн урамшууллыг нийгмийн даатгалд тайлагнаагүй зөрчил гаргасан ба Нийгмийн даатгалын тухай хуулийн 4-р зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 101-р зүйл заалт мөрдөж ажиллах.

Цахим баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээ хийсэн, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаагүй зөрчил дахин давтагдсан тул хариуцлага ноогдуулах албан шаардлага хүргүүлэх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээ хийсэн	1				1							
Цалингийн урамшууллаас НДШ тооцох	1	31,449.6			1	31,449.6						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>31,449.6</b>			<b>2</b>	<b>31,449.6</b>						

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн болон мэдээлээгүй	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	